



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын санал дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 72  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА М.МӨНХБАТ ТАНАА

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A41001

006000493

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4foot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,438,000.00</u></b>	<b><u>2,760,431.50</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	1,212,431.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,212,431.50
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,438,000.00	1,548,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,438,000.00	1,548,000.00
35420	Аж ахуйн материал	888,000.00	888,000.00
35470	Бусад хангамжийн материал	550,000.00	660,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>41,202,919.52</u></b>	<b><u>38,562,514.05</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	41,202,919.52	38,562,514.05
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	41,202,919.52	38,562,514.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,666,666.79	11,666,666.79
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,944,444.82	-11,666,666.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,836,503.00	55,788,073.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,020,797.97	-20,164,211.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,779,000.00	6,611,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,114,007.48	-3,672,747.48
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>42,640,919.52</u></b>	<b><u>41,322,945.55</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>42,640,919.52</u></b>	<b><u>41,322,945.55</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	42,640,919.52	41,322,945.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	42,640,919.52	41,322,945.55
51210	Өмнөх үеийн үр дүн	42,640,919.52	42,640,919.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,317,973.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>42,640,919.52</u></b>	<b><u>41,322,945.55</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>00.00</b>	<b>207,142,418.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>9,783,970.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	9,783,970.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	9,783,970.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	9,783,970.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>197,358,448.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	99,524,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	99,524,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	97,834,048.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	97,834,048.00

<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>208,460,391.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>208,460,391.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.00	208,098,166.97
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	00.00	84,778,873.88
210101	Үндсэн цалин	00.00	55,614,541.69
210102	Нэмэгдэл	00.00	18,541,166.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,420,236.93
210104	Урамшуулал	00.00	6,202,928.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	00.00	11,149,094.62
210201	Тэтгэврийн даатгал	00.00	8,138,999.09
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	843,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	675,000.09
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	168,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,322,595.44
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	13,900,243.00
210401	Бичиг хэрэг	00.00	514,300.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	11,201,043.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,767,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	417,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	83,121,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	82,026,705.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	5,875.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	950,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	00.00	15,148,675.47
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,724,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	12,424,375.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	362,225.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	244,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	244,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	118,225.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	118,225.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>-1,317,973.97</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>00.00</b>	<b>-1,317,973.97</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	42,640,919.52	00.00	42,640,919.52

Булган аймаг Статистикийн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>42,640,919.52</b>	<b>00.00</b>	42,640,919.52
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>42,640,919.52</b>	<b>00.00</b>	42,640,919.52
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>42,640,919.52</b>	<b>00.00</b>	42,640,919.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,317,973.97	00.00	-1,317,973.97
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>41,322,945.55</b>	<b>00.00</b>	41,322,945.55

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>00.00</b>	<b>197,358,448.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>197,358,448.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	99,524,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	99,524,400.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	97,834,048.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	97,834,048.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>00.00</b>	<b>197,358,448.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>197,358,448.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>196,996,223.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	00.00	85,775,650.00
210101	Үндсэн цалин	00.00	55,750,500.00
210102	Нэмэгдэл	00.00	19,273,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,294,200.00
210104	Урамшуулал	00.00	6,457,750.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	00.00	11,391,300.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	8,016,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	843,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	675,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	168,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,687,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	12,288,493.00
210401	Бичиг хэрэг	00.00	514,300.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	9,589,293.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,767,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	417,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	84,816,480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	83,801,905.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	5,875.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	870,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	00.00	2,724,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,724,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>362,225.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	244,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	244,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	118,225.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	118,225.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	00.00	99,406,175.00

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	00.00	99,406,175.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.00	99,162,175.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	00.00	84,381,400.00
210101	Үндсэн цалин	00.00	55,750,500.00
210102	Нэмэгдэл	00.00	19,273,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,294,200.00
210104	Урамшуулал	00.00	5,063,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	00.00	11,391,300.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	8,016,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	843,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	675,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	168,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,687,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	2,176,600.00
210401	Бичиг хэрэг	00.00	514,300.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	718,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	526,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	417,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	914,575.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	5,875.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	770,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	298300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	298,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	244000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	244,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	244,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	99,524,400.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	99,524,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	99,524,400.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>		
620001	Удирдах ажилтан		
620002	Гүйцэтгэх ажилтан		
620003	Үйлчлэх ажилтан		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>97,834,048.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>97,834,048.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	97,834,048.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,394,250.00
210104	Урамшуулал	1,394,250.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,111,893.00

210402	Тээвэр, шатахуун	8,871,093.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,240,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>83,901,905.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,801,905.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2426000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,426,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>97834048.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>97,834,048.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,834,048.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>80,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>80,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		80,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		80,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		80,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	80000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		80,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		80,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Д.Мягмарсүрэн, хоёр дахь хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, гурав дахь хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино.

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ:** Албан ёсны статистикийн бүртгэл хөтлөх, мэдээлэл гаргаж өгөх, дамжуулах, нэгтгэн боловсруулах, тооллого, судалгаа явуулах, дүгнэлт гаргах, мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тараах, хэвлэн нийтлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, сан байгуулах, хадгалах статистикийн бүх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахад чиглэгдэнэ.

Булган аймгийн Статистикийн алба нь 1960 оны 07-р сарын 25 нд “Тоо бүртгэлийн товчоо” нэртэйгээр байгуулагдан анхны даргаар М.Шагдарсүрэн томилогдон тоо бүртгэл хариуцсан байцаагч, мэдээ, тоо бүртгэл хариуцсан байцаагч гэсэн 3-н орон тоотой үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Мөн энэ ондоо бүх суманд бүртгэлийн ажил хариуцсан улсын байцаагч нар ажиллах болсон байна. 1964 оны 03-р сарын 06 -нд аймгийн “Тоо бүртгэлийн товчоо”-г аймгийн “Статистикийн товчоо” болгон өргөжүүлсэн байна.

Түүнчлэн аймгийн “Статистикийн товчоо” нь нийгмийн хөгжлийн өөрчлөлтийн дагуу бүтэц зохион байгуулалт үүрэг зорилтын хувьд өөрчлөгдөн “Статистикийн товчоо”, “Статистикийн хэлтэс”, “Санхүү Эдийн Засаг Үйлдвэрлэлийн хэлтсийн Статистикийн тасаг”, Засаг даргын дэргэдэх “Статистикийн хэлтэс” болон өргөжсөн төдийгүй улс орны нийгэм эдийн засгийн бүхий л салбарт өөрчлөлт гарч зах зээлийн эдийн засгийн харилцааг сонгон энэ замаар тууштай хөгжиж байгаа түүхэн шинэчлэлтийн үед статистикийн албаны үйл ажиллагаа шинэчлэгдэн өөрчлөгдөж 1994 оны УИХурлаар батлагдаж 1997 онд дахин нэмэлт өөрчлөлт оруулсан баталсан Монгол улсын “Статистикийн тухай” хуулийг мөрдлөг болгон үйл ажиллагаа явуулж байна.

Одоо аймгийн Засаг Даргын Дэргэдэх “Статистикийн хэлтэс” нь орчин үеийн тооцоолох техник хэрэгслээр бүрэн хангагдсан, дээд мэргэшлийн боловсон хүчинтэй үйл ажиллагаа явуулж байна.

Тус хэлтэс нь жилдээ 54 төрлийн албан ёсны мэдээ, 42 төрлийн захиргааны мэдээллийн 800 гаруй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 75 баг, 16 сум, 1 тосгоны анхан шатны нэгжээс батлагдсан маягт заавар аргачлалын дагуу цуглуулан дүн шинжилгээ хийн цахим хэлбэрээр ҮСХороонд дамжуулан, үр дүнг тархаан ажиллаж байна. Мөн бодлого боловсруулагчдыг хэрэгцээт мэдээллээр ханган ажиллаж байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд “ гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 70,405.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,056.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 739.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг Статистикийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8 923.1 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	00.0	00.0
Авлага	00.0	1,212.4	1,212.4
Бараа материал	1,438.0	1,548.0	110.0
Үндсэн хөрөнгө	41,202.9	38,562.5	( 2,640.4 )
<b>Нийт хөрөнгө</b>	<b>42,640.9</b>	<b>41,322.9</b>	<b>( 1,318.0 )</b>
Өр төлбөр	00.0	00.0	00.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/			
Дахин үнэлгээний зөрүү			
Хуримтлагдсан үр дүн	42,640.9	41,322.9	(1,318.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>42,640.9</b>	<b>41,322.9</b>	<b>(1,318.0)</b>

Тайлангийн хугацаанд цалин нийгмийн даатгалтай холбоотой 20,330.3 мянган төгрөгийн авлага үүсч 21,542.7 мянган төгрөг төлснөөр НДШ-ийн 1,212.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй болсон байна.

Бараа материалын данс 1,548.0 мянган төгрөг болж 110.0 мянган төгрөгөөр өссөн тайлангийн хугацаанд 17,336.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 17,226.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой. Тайлангийн хугацаанд 863.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 40.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, 16,215.2 мянган төгрөгийн шатах тосох материал 217.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал орлогодсон байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар статистикийн судалгааны ажилд 15,497.1 мянган төгрөгийн шатахуун 510.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 457.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материал зарцуулсан байна.

Төсвийн урсгал санхүүжилтээр 718,2 мянган төгрөгийн шатах тосох материал нийт 40,5 мянган төгрөгийн аж ахуйн материал нийт 17,226.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна

Үндсэн хөрөнгө дансанд тайлангийн хугацаанд статистикийн үндэсний хорооноос 7,275.6 мянган төгрөгийн 3 ширхэг компьютер, 1,832.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 9,783.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан. Тайлангийн хугацаанд худалдан авсан болон шилжүүлсэн, акталж устгасан хөрөнгө байхгүй байна. Жилийн эцсийн тооллогыг байгууллагын даргын тушаалаар хийж тооцоо бодож баталгаажуулсан байна.

Өмнөх үеийн үр дүн 42,640.9 мянган төгрөгийн ашигтай байсан ба тайлангийн хугацаанд (1,317.9) мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж хуримтлагдсан үр дүн 41,322.9 мянган төгрөгийн ашигтай болсон.

Булган аймаг Статистикийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт санхүүжилтийн орлого өмнөх оноос 152,783.4 мянган төгрөгөөр буюу 42.4 хувиар буурч , нийт зардал өмнөх оноос 119,077.2 мянган төгрөгөөр буюу 36.3 хувиар тус тус буурсан байна. Үүнд статистикийн судалгаа хийгддэг нэмэлт санхүүжилт 137,537.0 мянган төгрөгөөр буюу 59.8 хувиар буурсан нь тухайн тайлангийн хугацаанд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжлэн статистикийн судалгааны ажил цахимаар хийгдсэнтэй холбоотой.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Булган аймаг Статистикийн хэлтэс нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 99 524,6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 99 524.6 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 99 524.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 99,524.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж урсгал үйл ажиллагаанд 99,406.1 мянган төгрөгийг зарцуулж, 118.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган аймаг Статистикийн хэлтэс нэмэлт санхүүжилтээр статистикийн 13-н төрлийн судалгааны 92,262.6 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна. Мөн орон нутгийн засаг даргын нөөц хөрөнгийн 5,571.4 мянган төгрөгийн санхүүжилтыг авсан.

Үүнээс 2021 оны ӨНЭЗС болон АХСудалгаанд 47,678.2 мянган төгрөг, мал тэжээвэр амьтны тооллогын судалгаанд 5,571.4 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын судалгаанд 13,860.7 мянган төгрөг, статистикийн бусад тооллого судалгаанд 12 042.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн тээврийн хэрэгслийн ашиглалтын чанарыг сайжруулах засварлахад үндэсний статистикийн хорооны дэмжлэгээр 3,000.0 мянга төгрөг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Нэмэлт санхүүжилтээр статистикийн судалгааны ажил хийгддэг боловч баримтын иж бүрдэл дутуу судалгаанд ашигласан материалаа хувилж хавсаргасан, судалгааны баримт дээр баллаж засвар оруулдаг ба анхан шатны баримтын бүрдэл дутуу бараа материалын шаардах хуудас хоосон, гарын үсэг дутуу, тамга тэмдэггүй баримтууд байна.

Статистикийн үндсэн судалгаа болох ӨНЭЗС, АХСудалгааны өрхүүдэд хүрч ажилласан шатахуун зарцуулалтын жолоочийн замын хуудасны иж бүрдэл дутуу сум баг хоорондын зай километрийг албан ёсны маршрут мөрдөөгүй байна.

Мөн статистикийн үндсэн судалгаа болох ӨНЭЗС, АХСудалгааны өрхүүдэд хүрч ажилласан ажилтны судалгааны анхан шатны баримтанд засвар орсон мөн сумуудад томилолтоор явж судалгааг авахдаа зарим иргэд байхгүй байвал өөр хүнээр орлуулан авсан гэх ба томилолтын тайлан байхгүй байна.

Шатахууны тооцооллыг хийхдээ Тоёота Клугер маркийн авто машин 100км-т 20 литр бензин зарцуулахаар тооцоолсон байна. Судалгаанд ашиглаж байгаа машинуудтай гэрээг хангалтгүй, гэрээ байгуулаагүй ашигласан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь Булган аймаг Статистикийн хэлтсийн 2021 онд нийт 130 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах ёстойгоос хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайланд Бараа материалыг бүртгэхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт болон Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу бүртгэж тайлагнадаггүй аж ахуйн материалд бүх материалыг хольж бүртгэдэг ба материалын зардлыг мөн адил Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны 190 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу бүртгэж тайлагнаагүй байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар орж зарцуулагддаг зардлууд ангилал тус бүрээр тайлагнагддаггүй бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 210801 дансанд бүртгэгддэг байна. Аудитын явцад бүртгэлтэй холбоотой зөвлөмж зөвлөгөөг өгч ажилласан болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 66.7 хувьтай хангуулсан байна. Хэрэгжээгүй байгаа асуудал нь ажил гүйцэтгэх авто машин хөлслөх гэрээний гарын үсгийн иж бүрдэл дутуу байна. / Дүн нь тодорхой бус материал хангалтгүй байсан./

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-	-	-	-	-	-	
Албан шаардлага	-	-	-	-	-	-	
Зөвлөмж	3	-	2	-	1	-	
Нийт дүн	3	-	2	-	1	-	

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансаар, орсон санхүүжилтээр гарсан зардал тухай бүрд нь тайлагнаагүй бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс дансанд тайлагнаж байна. Цаашид зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар батлагдсан “ Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар ” журмын дагуу бүртгэж тайлагнахад анхаарах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4 алдаа зөрчил илэрч 378.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж , 2 албан шаардлага, 378.0 мянган төгрөгийн нэг төлбөрийн акт тавигдсан.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

## 4.2 Акт

Шатахууны тооцооллыг хийхдээ Тоёота Клугер маркийн авто машин 100км-т 20 литр бензин зарцуулахаар тооцоолсон байна. Статистикийн үндсэн судалгаа болох ӨНЭЗС, АХСудалгааны өрхүүдэд хүрч ажилласан шатахуун зарцуулалтын жолоочийн замын хуудасны иж бүрдэл дутуу сум баг хоорондын зай километрийг албан ёсны маршрут мөрдөөгүй байна. Үүнд 378.4 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын баримт хангалтгүй байгаа нь ЗТХС-ын 2019 оны 390 тушаалаар батлагдсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ын дагуу машин тус бүрээр тооцож тооцоог хийх, Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтуудыг зөрчиж байх тул төлбөрийн акт тавихаар шийдвэрлэсэн болно.

### Өгсөн акт:

Шатахууны тооцооллыг хийхдээ Тоёота Клугер маркийн авто машиныг техникийн үзүүлэлтээр шалгуулан зарцуулалтыг үнэн зөв тооцоолсон байна. Замын хуудас дээр дэлгэрэнгүй тоон мэдээлэл болон утгыг бүрэн бичих.

## 4.3 Албан шаардлага

1. ҮСХорооноос нэмэлт санхүүжилтээр ирсэн мөнгөнөөс 3000.0 сая төгрөгийн авто машины засвар үйлчилгээг Ургацын сор ХХК-аар гүйцэтгүүлсэн боловч машины эвдрэлийн акт байхгүй ямар эд анги солигдож, ямар засвар үйлчилгээ хийгдсэн нь тодорхойгүй, ажил хийж гүйцэтгэсэн акт байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.гэсэн заалтуудын дагуу бодитой баримт материалд үндэслэн зарцуулж тайлагнах гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

2. Нэмэлт санхүүжилтээр статистикийн судалгааны ажил хийгддэг боловч баримтын иж бүрдэл дутуу судалгаанд ашигласан материалаа хувилж хавсаргасан, судалгааны баримт дээр баллаж засвар оруулдаг ба анхан шатны баримтын бүрдэл дутуу бараа материалын шаардах хуудас хоосон, гарын үсэг дутуу, тамга тэмдэггүй баримтууд байна. Нэмэлт санхүүжилтийн зардалд 900.0 мянган төгрөгийн хувь хүний сугалаатай баримтаар гүйлгээ хийсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна. Гэсэн хуулийн заалтуудыг зөрчиж байна. Иймээс дээрх 2 асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:**

Тайлангийн хугацааны эцэст 1 212.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Өр авлага үүсгэхгүй байх .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/


д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган аймаг Статистикийн хэлтэс	4	378.4			1	378.4	2	-	1	-
	Дүн	4	378.4			1	378.4	2	-	1	-

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**БЭЛТГЭСЭН:**

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

**ХЯНАСАН:**

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :



Д.МЯГМАРСҮРЭН

**АНХАН ШАТАНД ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦООДОЛ

**ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР